



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 09 өдөр

Дугаар A/93

Арвайхээр

Г Уураг, амин дэмээр баяжуулсан эрдсийн
шахмал тэжээлийн нөөц бүрдүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Өвөрхангай аймгийн Онцгой комиссын 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 01 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын онцгой комиссиос 2019 оны 11 дүгээр сард аймгийн өвөлжилтийн нөхцөлд хийсэн үнэлгээгээр 16 суманд эрсдэлийн түвшин их, 2 сум дунд, 1 сум бага эрсдэлтэй гарсан байх тул зудын эрсдэлийг хохирол багатай даван туулах зорилгоор аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцөд 3000 (гурван мянга) ширхэг эрдсийн шахмал тэжээл (долооц)-ыг 16.500.000 (арван зургаан сая таван зуун мянга) төгрөгөөр “Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн”-ийн дэргэдэх “Гарааны анар эрдэс тэжээл” ХХК-аас худалдан авахыг зөвшөөрсүгэй.

2. Шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, эрдсийн шахмал тэжээлийн сав баглаа боодол болон гарал үүсэл зэрэгт хяналт тавьж, сумдад хуваарилалт хийж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир)-т даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу аймгийн гамшигаас хамгаалах эрсдлийг бууруулах арга хэжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД

011100201

D:My Doc. Zahiramj. Zasag darga